



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 237

Улаанбаатар хот

“Гэр даатгал” ХХК-д дүрмийн сан  
/хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээндээ  
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.3.2, 21.5, 22.1, 73.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Гэр даатгал” ХХК-ийн дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээг тус компанийн 2011 оны хуримтлагдсан ашгаас нийт 299,000,000 /хоёр зуун ерэн есөн сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараахь байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:


	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	А.Гансүх	500,000,000	149,500,000	649,500,000	50 хувь
2	“Вектор Интэрнэшнл” ХХК	500,000,000	149,500,000	649,500,000	50 хувь
	Дүн	1,000,000,000.0	299,000,000.0	1,299,000,000.0	100 хувь

2. “Гэр даатгал” ХХК-д өөрийн дүрмийн сангаа Хорооноос тогтоосон доод хэмжээнд 2012 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргэхийг даалгасугай.

3. Дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2012 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Гэр даатгал” ХХК /Г.Баттогтох/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН